

4 ДУГУЙТ МОТОЦИКЛ ЖОЛООДОХ ЖУРАМ

1. Энэхүү гэрээний түрээслэгч тал заавал 18 нас хүрсэн байх шаардлагатай.
2. Мотоцикл жолоодохдоо заавал зориулалтын өөрт тохирсон хамгаалалтын малгай өмссөн байх ёстой. Мөн цээж, нуруу, гар, хөлийн хамгаалалт зүүж өмссөнөөр гэмтэл бэртэлийн эрсдэлийг буруулах боломжтой.
3. Мотоциклийн зорчигчид бүгд суудалд суун хамгаалалтын бүсийг зөв бэхлэснээр хөдөлгөөн эхлэх ёстойг түрээслэгч буюу жолоодогч анхааруулж, ёсчлон биелүүлнэ.
4. Жолоо барихын өмнө болон жолоо барьж байх хугацаанд түрээслэгч согтууруулах ундаа, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл хэрэглэхийг огт зөвшөөрөхгүй. Энэхүү шаардлагыг биелүүлээгүйн улмаас үүдэн гарах бүхий л эрсдэл, алдагдлыг дангаар хариуцна.
5. Зөвшөөрөгдсөн хурдны заалтыг чанд баримтлан жолоодно.
6. Үйлдвэрээс зөвшөөрөгдсөн зорчигчийн тоог баримтлана.
7. Өөрийн ур чадварт тохируулж жолоодох бөгөөд үүнээс хэтрүүлэх нь аюултай тул маш болгоомжтой жолоодоно.
8. Зөвхөн гэрээнд заасан чиглэл, замын дагуу явна.
9. Мотоциклийг хэт бохирдуулсан тохиолдолд нэмэлт төлбөр төлнө.
10. Мотоциклийг онхолдуулан тохиолдолд 5,000,000 төгрөгийн торгуультай бөгөөд тэрхүү эвдрэл гэмтлээс үүдсэн сэлбэг хэрэгслийг бүрэн төлж барагдуулахаас гадна засвар үйлчилгээний ажлын хөлс болох 80,000 төгрөг хүн/цаг төлбөрийг дангаар хариуцна.
11. Гэрээний хугацаанд бусад аялагчийн отог, хамгаалалтын бүс, амралтын газар, нийтийн эзэмшлийн зам талбайд зүй бусаар харьцахийг хатуу хориглоно. Дээрх бүсэд 30 км/цагаас дээш хурдтай явахыг хориглоно.
12. Өөр хоорондоо болон бусад мотоцикл, тээврийн хэрэгсэлтэй уралдахыг хатуу хориглоно.
13. Бусад мотоциклийг чирэх, татах, угзрах хориотой. Мөн өөрөө чирүүлэх, татуулах, угзруулахыг хориглоно.
14. Зогсолт хийхдээ дугуйнд эвүүр хийж гулсах, уруудах, хальтрахаас хамгаалж аюулгүй зогсолт хийнэ.
15. Хурц өнцөг бүхий хад, чулуу, хадаас гэх мэт дугуй болон обуд, гар, амортизатор, пүрш гэмтэх, эвдрэхээс сэргийлнэ. Гэмтэж эвдэрсэн тохиолдолд түрээслэгч тал бүрэн хариуцаж хохиролгүй болгоно.
16. Бусад жолооч, түрээслэгч нараас зай барьж, цаг агаарын болон замын нөхцөл байдалд тохирсон хурдтай, аюулаас сэргийлж бүрэн зогсолт хийх боломжтойгоор жолоог барина.
17. Аялалын явцад сайтар бэлтгэлтэй явна. Бүрэн цэнэгтэй үүрэн эсвэл сансрын утас, цаг агаарын нөхцөлд тохирсон хувцас, газрын зураг, луужин, цэвэр ус зэргийг заавал авч аялана.
18. Аялалын маршрутаас гадуур замаар аялах, мэдэхгүй замаар явах, шинээр зам гаргах зэрэг эрсдэлтэй үйлдэл нь таныг нэмэлт төлбөрт төлөхөд төлөхөд хүргэж болзошгүйг анхаарна уу.
19. Гэрээний хугацаанд ямар ч тохиолдолд мотоциклийг орхиж явахыг хориглоно. Таныг мотоциклтой хамт байхыг зөвлөж байна. Хэрвээ үүнээс үүдэж мотоцикл алга болсон, хулгайд алдагдсан тохиолдолд та мотоциклийг цоо шинээр төлж барагдуулна.
20. Гэмтэл, эвдрэл болсон тохиолдолд мотоциклийг орхилгүйгээр операторын дугаарт мэдэгдэж тусламж дуудна. Энэ хугацаанд түрээсийн хугацааг түрээслүүлэгчийн үнэлгээний дагуу түрээслэгч төлнө. Холбоо барих операторын дугаар: 8888-3888
21. Хэрэв дээрх нөхцөлүүдийг биелүүлээгүй бол түрээслүүлэгч тал нэмж торгууль оногдуулна.
22. Мотоциклийг түрээсийн хугацаанаас хэтрүүлсэн, хоцорсон цаг тутамд түрээслэгч нэмэлт төлбөр төлнө.
23. Түрээсийн хугацаанаас өмнө мотоциклийг хүлээлгэж өгсөн тохиолдолд төлбөрийн буцаалт байхгүй болно.
24. Цаг агаараас шалтгаалж түрээсийн хугацаанаас өмнө мотоциклийг хүлээлгэж өгсөн тохиолдолд төлбөрийн буцаалт байхгүй болно.
25. Та 3 цаг тутамд шатахууны заалтыг шалгаж, шатахуун дүүргэж байна.
26. Мотоциклийн бүрэн бүтэн байдалд үргэлж анхаарч, болгоомжтой жолоодоно уу. Хэрэв эвдэлсэн тохиолдолд түрээслэгч би болон бид 10,800 ам.долларыг өнөөдрийн дотор төлж барагдуулахыг би болон бид зөвшөөрч байна. Төлбөрийг барагдуулж чадаагүй бол энэхүү төлбөр дээр бизнесийн орлогыг нэмж төлнө гэдгийг үүгээр баталгаажуулж гарын үсгийг дор зурж байна.

27. Хэзээ ч мотоциклийг үсэргэж, хариалгаж болохгүй. Үүнээс үүдэн амортизатор пүрш гар зэрэг эвдэрч гэмтэх аюултай. Эдгээр сэлбэг нь өндөр үнэтэй тул анхаарна уу. Мөн түрээслэгч та засварын хугацаанд сэлбэг болон ажлын хөлс, мотоцикл ажиллахгүй байх бизнесийн зардлыг төлнө.
28. Огцом эргэх үйлдэл хийхийг хатуу хориглоно. Үүнээс үүдэж дугуй обуднаас мултрах, мотоцикл хажуулах, онхолдох зэрэг аюултай. Онхолдуулах, хажуулдуулах торгууль нь хамгийн бага даа 5,000,000 төгрөг болно. Дугуй засварын төлбөр 50,000 - 150,000 төгрөг.
29. Ремин гэмтэх гол шалгаан нь мотоцикл шавар, намаг, гол ус, элс, хайрганд сууж, түүнээс гаргах гэж хүчлэх юм. Мөн эгц өөд хүчлэх үүнд багтана. Ремин солих зардал 900,000 төгрөг байна.
30. Огцом өсгүүр, огцом уруу, огцом налуу зэрэг замыг анхааралтай харж, ажиглаж жолоодоно уу. Бусад тээврийн хэрэгсэлээс 10-15метрийн зай барьж явах бөгөөд хэт ойрхон жолоодох нь аваар гарч болзошгүй нөхцөл байдлыг үүсгэх бөгөөд амь нас эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах боломжтой юм.
31. Зорчигч суудлын даруулгыг хөдөлгөөн эхлэхээс өмнөбайнга бүслэж, урд зориулалтын бариулаас барьж хоёр хөлөө гишгүүр дээр байрлуулж явна. Зорчигчийг ямар ч тохиолдолд хамгаалалтын төмөрөөс барих, хаалганы хүрэнээс бариулахыг хориглоно. Зорчигч хамгаалалтын малгайг зориулалтын даруулга, бүчээр зөв бэхлэж өмссөн байна. Хөдөлгөөн эхлэхээс өмнө зорчигчийн байрлал, хамгаалалтын малгай өмссөн эсэхийг давхар шалгаж байх нь жолоодогчийн/түрээслэгчийн үүрэг юм.
32. Түрээслүүлэгч, түрээслэгч таныг мотоциклд 12-оос доош насны хүүхэд хамт зорчихыг хатуу хориглож байна. Мөн хүүхдийг жолооны суудалд, өөрийн урд суулгаж жолоо барихыг хатуу хориглоно.
33. Хэрэв танд ямар нэгэн механик гэмтэл гарсан мэт санагдсан, мэдрэгдсэн тохиолдолд хөдөлгөөнийг зогсоож, манай операторыг дуудаж шалгуулна уу.
34. Зөвшөөрөгдсөн зам талбайгаас гадуур аялаж явахгүй байх нь аливаа эрсдэлээс хамгаалах болно.
35. Хөдөлгөөн эхлэхдээ хөдөлгүүрт эргэлтийн ачаалал өгөхгүйгээр явах араанд/D/ шилжүүлнэ. Мөн дифференциал цоожлогч, 4-дугуй хөтлөгч холбосон үед хөдөлгүүрийг өндөр хурдаар эргүүлэх,огцом эргэх хөдөлгөөн хийхгүй байх. Дугуй эргэлттэй болон явж байх үед араа шилжүүлэхгүй байх.
36. Түрээслүүлэгч тал эвдрэл, гэмтлийг оношлуулсны дараа төлбөрийн дүнг өөрчлөх эрхтэй. Түрээсийн хугацаанд гэмтээсэн, эвдсэн буюу учруулсан хохирол даатгалд тусгагдаагүй зөвхөн түрээслэгч та хариуцаж төлнө.
37. Түрээслэгч жолоог гэрээ хийсэн этгээдээс бусад этгээдэд шилжүүлэхгүй байх үүрэгтэй. Мөн насны доод хязгаарын заалтыг /18-аас дээш/ чанд мөрдөнө.
38. Хурдны дээд хязгаарыг үргэлж баримтална.
39. Энэхүү журам нь жуулчны/түрээсийн гэрээний салшгүй нэг хэсэг болно.

ЗӨВШӨӨРСӨН ТҮРЭЭСЛЭГЧ НАР/ОПЕРАТОР/НЭМЭЛТ ЖОЛООДОГЧ/ЭЦЭГ ЭХ

| | | | | | |
|-----|------------|-----|-----|------------|-----|
| нэр | гарын үсэг | нас | нэр | гарын үсэг | нас |
| | | | | | |
| нэр | гарын үсэг | нас | нэр | гарын үсэг | нас |
| | | | | | |
| нэр | гарын үсэг | нас | нэр | гарын үсэг | нас |
| | | | | | |
| нэр | гарын үсэг | нас | нэр | гарын үсэг | нас |
| | | | | | |